



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/496

Мөрөн сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXVIII/36 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXVIII/36 дугаар тоот тогтоолыг хэрэгжүүлэн Мөрөн сум 8 дугаар багт байрлах Нутгийн аваргууд бага сургууль аймгийн Засаг даргын Тамгын газрын эзэмшлийн 6049 м² газрыг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг ханган, төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Улам-Өсөх – (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Х.Цэнд-Аюуш- (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга)

Б.Сумьяабат- (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны мэргэжилтэн)

Б.Бат-Оргил- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Х.Мөнх-Эрдэнэ- (Худалдан авах ажиллагааны газрын Ахлах мэргэжилтэн)

Д.Сандагдорж- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Х.Буянтогтох- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. Дээр төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж холбогдох шийдвэр гарган хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ